

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/02

Арвайхээр сум

Зөвлөлийн бүрэлдэхүүн томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/550 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийн тохиолдол бүрийг хэлэлцэн нөлөөлсөн шалтгаан нөхцөл хожимдлыг судлан дүгнэлт шийдвэр гаргах, цаашид хүндрэл эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг тооцон ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалыг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров)-д, хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай” А/33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 30 өдрийн
А/01 дугаар тушаалын хавсралт

ИХОЕ0007

ЭХИЙН ЭНДЭГДЭЛ, НОЦТОЙ ХҮНДРЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн газрын Эх барих эмэгтэйчүүдийн тусламж хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн газрын анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотрын зөвлөх эмч Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрчимт эмчилгээний зөвлөх эмч Шаардлагатай тохиолдолд аймгийн бусад эмч, мэргэжилтнүүд